# БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 09 өдөр Дугаар 125 Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг тус тус үндэслэн "Үндэсний хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 202 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. "150 мянган айл-Орон сууц" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. "150 мянган айл-Орон сууц" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг холбогдох байгууллагуудад хүргүүлэх, мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, шаардагдах хөрөнгийг улсын төсөв, гадаад, дотоодын зээл тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/-д үүрэг болгосугай.

3. "150 мянган айл-Орон сууц" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, тайланг жил бүр Сайдын зөвлөлд, хоёр жил тутамд Засгийн газарт танилцуулж байхыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Нарантуяа/-т үүрэг болгосгай.

Х.БАДЕЛХАН

08 00392

Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 07 дугаар сарын 09 -ны өдрийн 125 дугаар тушаалын хавсралт

**"150 МЯНГАН АЙЛ-ОРОН СУУЦ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа | № | Бүтээгдэхүүн | Хэрэгжүүлэх хугацаа, оноор | Шаардагдах хөрөнгө | | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин, 2018 он | Хүрэх түвшин, үр дүн /оноор/ | | | | | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төсөв (сая төгрөг) | Эх үүсвэр | | | 2019 он | 2020 он | 2021 он | 2022 он | 2023 он | Үндсэн | Хамтрагч |
| **Зорилго: Төв, суурин газарт амьдардаг өрхүүдийн дийлэнх олонхи нь өөрсдийн худалдан авах чадварт нийцсэн, манай орны цаг уурын нөхцөлд тохирсон, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан, инженерийн бүрэн хангамжтай орон сууцтай болох нөхцлийг бүрдүүлэх** | | | | | | | | | | | | | | |
| **Зорилт1.Орон сууцны санхүүжилтийн тогтолцоо, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр** | | | | | | | | | | | | | | |
| 4.1.1.иргэдийн орон сууцны хангамж, нөхцлийг сайжруулахад чиглэсэн санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх; | 1 | Орон сууцны тухай болон Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулиудыг нэгтгэн, Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барина. | 2019-2020 | 38.0 | Бусад эх үүсвэр | Батлагдсан хууль | - | Хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барина. | Хуулийг УИХ-аар батлуулна. | Хуулийг мөрдөж, хэрэгжүүлнэ. | | | Барилга, хот байгуулалтын яам | Хууль зүй, дотоод хэргийн яам |
| | 2 | Орон сууцны хөнгөлөлттэй зээлийг үнэт цаасжуулах үйл ажиллагааг хялбаршуулах, зардлыг бууруулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулна. | 2019-2020 | - | - | Батлагдсан хууль тогтоомж | - | Судалгаа хийж, төслийг боловсруулна. | Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барьж батлуулна. | Хэрэгжилтийг хангаж ажиллана. | | | Сангийн яам | Хууль зүй, дотоод хэргийн яам, Санхүүгийн зохицуулах хороо |
| | 3 | Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, 23.4-д заасны дагуу амьдран суух зориулалтаар анх удаа зөвхөн хувьдаа орон сууцны барилга барьсан, эсхүл орон сууц худалдан авсан Монгол Улсын иргэнд зарцуулсан хөрөнгөтэй тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг эдлүүлнэ. | 2019-2023 | - | Улсын төсөв | Татварын хөнгөлөлтөд хамрагдсан иргэдийн тоо | - | Үйл ажиллагааны гүйцэтгэлээр | | | | | Сангийн яам | Татварын ерөнхий газар |
| | 4 | Иргэдийн орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зээлийн урьдчилгаа төлбөрийг тэдний тэтгэврийн даатгалын нэрийн дансны хуримтлалаас бүрдүүлэх боломжийг судалж, санал боловсруулна. | 2020-2021 | - | - | Боловсруулсан санал | - | - | Санал боловсруулж, холбогдох шийдвэрийг гаргуулсан байна. | | - | - | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам |
| | 5 | Газрын нөхөн олговрын үнэлгээний аргачлалыг боловсруулж хэрэгжүүлнэ. | 2019-2020 | - | - | Батлагдсан аргачлал | - | Судалгаа хийсэн байна. | Аргачлалын төслийг боловсруулж батлуулна. | Хэрэгжилтийг хангаж ажиллана. | | | Барилга, хот байгуулалтын яам | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар |
| 4.1.2.орон сууцны даатгалын тогтолцоог боловсронгуй болгох. | 1 | Орон сууц ашиглалтын байгууллага мэргэжлийн хариуцлагын даатгалд заавал даатгуулах, сууц өмчлөгч хариуцлагын сайн дурын даатгалд даатгуулах ажлыг зохион байгуулна. | 2019-2020 | - | - | Даатгалд хамрагдсан Орон сууц ашиглалтын байгууллага, сууц өмчлөгчдийн эзлэх хувь | - | 20 | 40 | 60 | 80 | 100 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Даатгалын байгууллагууд |
| 4.1.3.орон сууц ашиглагч байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг оновчтой тогтоох, орон сууцны барилгын засвар үйлчилгээнд зориулж | 1 | Орон сууцны ашиглалт хариуцсан мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны стандартыг шинэчилж боловсруулж, батлуулна. | 2020-2021 | 20.0 | Барилга, байгууламжийн норм, нормативын сан | Батлагдсан стандарт | - | Зөвлөхийг сонгон шалгаруулж, төслийг боловсруулалтыг эхлүүлнэ. | Стандартыг батлуулна. | Хэрэгжилтийг хангаж ажиллана. | | | "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ | Стандарт хэмжилзүйн газар |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| үйлчилгээнд зориулж иргэдийн хуримтлуулсан хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах нөхцлийг бүрдүүлэх; | 2 | Орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээний зардлыг тооцох аргачлалыг боловсруулж, батлуулна. | 2020-2021 | - | - | Батлагдсан аргачлал | - | - | Зөвлөхийг сонгон шалгаруулж, төслийн боловсруулалтыг эхлүүлнэ. | Аргачлалыг батлуулна. | Хэрэгжилтийг хангаж ажиллана. | | "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ | Барилга, хот байгуулалтын яам |
| | 3 | Аймаг, нийслэлийн Засаг даргын Орон сууцны ашиглалт хариуцах мэргэжлийн байгууллагын удирдлагатай байгуулах гэрээний жишиг загварыг боловсруулж батлуулна. | 2020-2021 | - | - | Батлагдсан гэрээний загвар | - | - | Төслийг боловсруулна. | Гэрээний загварыг батлуулна. | Хэрэгжүүлж ажиллана. | | "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ | Барилга, хот байгуулалтын яам |
| | 4 | Орон сууцны ашиглалт, засвар, үйлчилгээг хариуцах мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулах журмыг боловсруулж батлуулна. | 2020-2021 | - | - | Батлагдсан журам | | - | Журмын төслийг боловсруулна. | Журмыг батлуулна. | Журмыг мөрдүүлнэ. | | "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ | Барилга, хот байгуулалтын яам |
| | **Дүн** | | | **58.0** | | | | | | | | | | |
| **Зорилт 2.Хот суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, орон сууцны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллыг иргэдийн оролцоотой дахин төлөвлөх замаар байгаль орчинд ээлтэй, ашиглалтын зардал багатай инженерийн дэд бүтцэд холбогдсон тохилог гэр, амины болон нийтийн орон сууцны хороолол болгон хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр** | | | | | | | | | | | | | | |
| 4.2.1.төв суурин газрын гэр хорооллын газрыг иргэдийн шууд оролцоотойгоор дахин төлөвлөж, газрыг зүй зохистой ашиглах хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх; | 1 | Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулна. | 2019-2020 | - | - | Батлагдсан хууль | Суурь судалгаа, тайлан | Төслийг боловсруулна. | ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барина. | Хуулийг УИХ-аар батлуулна. | Хуулийг мөрдөж, хэрэгжүүлнэ. | | Барилга, хот байгуулалтын яам | Хууль зүй, дотоод хэргийн яам |
| | 2 | Инженерийн хангамжийн цогц шийдэл бүхий "Ногоон сууц" хотхоны нэг маягийн зураг төслийг боловсруулж батлуулан олон нийтийн хүртээл болгоно. | 2019-2020 | 50.0 | НҮБХХ-ийн санхүүжилт | Боловсруулсан зураг төсөл | | Зураг, төслийг батлуулж, олон нийтийн хүртээл болгоно. | - | - | - | - | Барилга, хот байгуулалтын яам | Зураг, төслийн байгууллага |
| | 3 | "Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм" БНбД 30-01-04-ийг шинэчлэн боловсруулж, батлуулна. | 2019 | 20.0 | Барилга, байгууламжийн норм, нормативын сан | Шинэчлэгдсэн БНбД | | БНбД 30-01-04-ийг шинэчлэн боловсруулж, батлуулна. | - | - | - | - | Барилга, хот байгуулалтын яам | "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ |
| | 4 | Гэр хорооллын газрыг дахин төлөвлөж, барилгажуулах төслийг үе шаттай хэрэгжүүлж, 45000 айлын орон сууцыг ашиглалтад оруулна. | 2019-2023 | 3,024,000.0 | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | Ашиглалтад орсон сууцны тоо | 5189 | 6000 | 10000 | 10000 | 10000 | 9000 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Барилга, хот байгуулалтын яам |
| | 5 | Гэр хорооллын газрыг дахин төлөвлөж, барилгажуулах төслийн хүрээнд ашиглалтад орсон орон сууцнуудаас худалдан авах иргэдэд нэн хөнгөлөлттэй зээл олгуулах механизмыг тодорхойлж, зээл олгуулах ажлыг зохион байгуулна. | 2019-2023 | 1,890,000.0 | Гадаад, дотоод хөнгөлөлттэй зээл | Зээлд хамрагдсан өрхийн тоо | - | 4200 | 7000 | 7000 | 7000 | 6300 | Сангийн яам, Монгол Улсын Хөгжлийн банк | Барилга, хот байгуулалтын яам |
| | 6 | Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийг 50 байршилд хэрэгжүүлж, 13500 өрхийг инженерийн бүрэн хангамжид холбоно. | 2019-2023 | 621,000.0 | Улс, нийслэлийн төсөв, гадаад орнуудын зээл, тусламж | Инженерийн бүрэн хангамжид холбогдсон өрхийн тоо | - | 600 | 1200 | 3600 | 3600 | 4500 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Барилга, хот байгуулалтын яам |
| | 7 | Инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулах замаар аймаг бүрт гэр хорооллын 600-аас доошгүй өрхийг инженерийн хангамжид холбож, орон сууцны нөхцлийг сайжруулна. | 2019-2020 | - | Салбарын мэргэжлийн байгууллагуудын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сан | Инженерийн хангамжид холбогдсон өрх | - | 1520 | 2600 | 3000 | 3000 | 2480 | Аймгуудын Засаг дарга | Аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 8 | Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, "Ногоон нуур" орчимд 1008 айлын орон сууцыг барьж ашиглалтад оруулна. | 2019-2020 | 985.0 | БНХАУ-ын буцалтгүй тусламж /Монголын талын хөрөнгө/ | Ашиглалтад орсон сууцны тоо | - | - | 1008 | | | | Барилга, хот байгуулалтын яам | Төслийн нэгж |
| | 9 | Улаанбаатар хотод иргэдийн худалдан авах чадварт нийцсэн, эко орон сууцны төслийг хэрэгжүүлж, 10000 айлын орон сууцыг үе шаттайгаар барьж, ашиглалтад оруулна. | 2019-2023 | 1,425,250.0 | АХБанкны хөнгөлөлттэй зээл, Уур амьсгалын ногоон сан, Дэвшилтэт технологийн сан, Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | Ашиглалтад орсон орон сууцны тоо | - | - | 2500 | 2500 | 2500 | 2500 | Нийслэлийн орон сууцны корпораци ХК, | "Эрэл" групп |
| | 10 | Нийслэлийн Баянзүрх дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Цайз зах орчимд иргэдийн оролцоотой газар дахин зохион байгуулах "Цайз эко хотхон" 712 айлын орон сууцыг барьж ашиглалтад оруулна. | 2019-2023 | 82,639.0 | Улс, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | Ашиглалтад орсон сууцны тоо | - | - | - | 230 | 230 | 252 | "Нийслэлийн орон сууцны корпораци" ХК | Хувийн хэвшил |
| | 11 | Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийг хэрэгжүүлэхэд төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээл, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлж ажиллана. | 2019-2023 | - | Гадаад орнуудын хөнгөлөлттэй зээл, төр хувийн хэвшлийн түншлэл | Хэрэгжүүлсэн төсөл, тоо | - | Үйл ажиллагааны гүйцэтгэлээр | | | | | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Барилга, хот байгуулалтын яам |
| | 12 | Гэр хорооллын газрыг дахин төлөвлөлтэй холбогдсон мэдээ мэдээллээр хангах, сургалт, уулзалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх, иргэдийн идэвхи санаачлагыг өрнүүлэх, иргэдийн бүлэг байгуулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллана. | 2019-2023 | - | - | Иргэдийн бүлгийн тоо | - | Үйл ажиллагааны гүйцэтгэлээр | | | | | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга |
| | 13 | Дулааны эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, ашиглалтын найдвартай байдлыг хангах, төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээг өргөтгөх, шинэчлэх, төвлөрсөн дулаан хангамжид холбогдох боломжгүй газруудад шинээр эх үүсвэр, шугам сүлжээг барьж байгуулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2019-2023 | 16,016.0 | Гадаад орнуудын хөнгөлөлттэй зээл | Хэрэгжүүлсэн төсөл, тоо | - | Үйл ажиллагааны гүйцэтгэлээр | | | | | Эрчим хүчний яам | Эрчим хүчний зохицуулах хороо холбогдох тусгай зөвшөөрөл эзэмшигчид |
| 4.2.2.инженерийн хангамжийн шугам сүлжээ, барилга байгууламжийг шинээр барих, шинэчлэх, өргөтгөх төслийг үе шаттай хэрэгжүүлж, орон сууцны хотхон хороолол, түүний нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийг барих нөхцлийг бүрдүүлэх; | 1 | Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий шинэ төв цэвэрлэх байгууламжийг барьж, ашиглалтад оруулна. | 2019-2022 | 750,000.0 | Улсын төсөв, БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл | Төслийн хэрэгжилтийн хувь | - | 10 | 40 | 80 | 100 | - | Барилга, хот байгуулалтын яам | Нийслэлийн Засаг дарга |
| | 2 | Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид лагийг бүрэн боловсруулах, дахин ашиглах технологийг нэвтрүүлнэ. | 2019-2020 | 25,000.0 | | Төслийн хэрэгжилтийн хувь | - | 50 | 100 | - | - | - | | |
| | 3 | Дархан-Уул, Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь, Баян-Өлгий, Дорнод, Увс, Завхан, Говьсүмбэр, Хэнтий, Дундговь аймгийн төвүүдэд цэвэрлэх байгууламж шинээр барих, шинэчлэх төслийг хэрэгжүүлнэ. | 2019-2023 | 132,556.9 | Гадаад орнуудын хөнгөлөлттэй зээл | Шинээр ашиглалтад орсон цэвэрлэх байгууламж | - | 1 | 3 | 3 | 3 | 2 | Барилга, хот байгуулалтын яам | Аймгуудын Засаг дарга нар |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 4 | Нийслэлийн цахилгаан дамжуулах болон түгээх сүлжээ, дэд станцуудыг өргөтгөн хүчин чадлыг нь нэмэгдүүлж, гэр хорооллын айл өрх 2.5-4.0 квт хүчин чадалтай цахилгаан халаагуур ашиглах техникийн боломжийг бүрдүүлнэ. | 2019-2023 | 20,000.0 | Гадаад орнуудын хөнгөлөлттэй зээл | 110 000 айл өрхийг 2,5 кВт, 88 000 айл өрхийг 4,0 кВт хүчин чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн боломж | - | 20000/18000 | 20000/18000 | 25000/20000 | 25000/20000 | 20000/12000 | Эрчим хүчний яам | Нийслэлийн Засаг дарга |
| | 5 | Шинээр төлөвлөх орон сууцны хорооллын унд-ахуйн хэрэглээний цэвэр усыг тусад нь төлөвлөх, гарсан бохир усыг дахин боловсруулж, ариутгах татуургын системд технологийн зориулалтаар болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах зэрэг техникийн шийдлийг зураг төсөлд тусгаж, хэрэгжүүлнэ. | 2019-2023 | - | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Хэрэгжүүлсэн төсөл, тоо | - | - | 5 | 5 | 5 | 5 | Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар, Аймгуудын газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | Барилгын зураг төсөл зохиогчдын холбоо |
| | 6 | Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд баригдах орон сууцнуудын инженерийн шугам сүлжээний хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар шийдвэрлэж ажиллана. | 2019-2023 | 212,734.8 | Улс, орон нутгийн төсөв, гадаад орнуудын зээл, тусламж | Тухайн жилд шийдвэрлэсэн санхүүжилт, сая төгрөг | - | 20,000.0 | 40,000.0 | 50,000.0 | 50,000.0 | 52,734.8 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Барилга, хот байгуулалтын яам |
| | 7 | Гэр хороололд шинээр бий болох орон сууц, түүний инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн ашиглалтын хэвийн, найдвартай ажиллагааг хангаж ажиллана. | 2019-2023 | - | - | Мэргэжлийн байгууллагын үйлчилгээний хүртээмж, хувь | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Салбарын мэргэжлийн байгууллагууд |
| 4.2.3.өндөр технологийн, ухаалаг, бие даасан дэд бүтцийг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, гадаад, дотоодын зээл, тусламж, концессийн гэрээгээр барьж байгуулахыг дэмжих, байгалийн нөөцийн хэмнэлттэй, дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэх, нутагшуулах; | 1 | Ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн системд холбогдоогүй 1500-аас доошгүй айл өрх, аж ахуйн нэгж байгууллагыг байгаль орчинд халгүй, бие даасан шийдэл бүхий ариун цэврийн байгууламжтай болгох төслийг хэрэгжүүлнэ. | 2019-2020 | 10,000.0 | Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламж | Төслийн хэрэгжилт, хувь | - | 500 | 1000 | - | - | - | Байгаль орчин, аялал жуулчлалын яам, | Барилга, хот байгуулалтын яам |
| | 2 | Усны хэрэглээний зохистой менежментийг нэвтрүүлэх, хөрсний болон хур тунадасны усыг хуримтлуулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах төслийг хэрэгжүүлж эхлэнэ. | 2020-2023 | - | Олон улсын байгууллага, гадаадын хөрөнгө оруулалт | Төслийн хэрэгжилт | - | - | Үйл ажиллагааны гүйцэтгэлээр | | | | Нийслэлийн Засаг дарга | Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Барилга, хот байгуулалтын яам |
| | 3 | "Тайшир-Алтай" төслийг хэрэгжүүлж, Алтай хотын иргэдийг стандартын шаардлага хангасан унд ахуйн ус хангамжийг нэмэгдүүлнэ. | 2019-2021 | 33,600.0 | Австрийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээл | Төслийн хэрэгжилт, хувиар | - | 30 | 70 | 100 | - | - | Барилга, хот байгуулалтын яам | Сангийн яам |
| | **Дүн** | | | **8,243,851.7** | | | | | | | | | | |
| **Зорилт 3.Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал багатай, ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг дэмжих чиглэлээр** | | | | | | | | | | | | | | |
| 4.3.1.хот, суурин газрын хэт төвлөрлийг саарсуулах, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлэх хүрээнд дагуул, хаяа хот, дүүрэг, тосгодыг жигд тэнцвэртэйгээр | 1 | Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт "Солонго-1" төслийг хэрэгжүүлж, 4320 айлын орон сууц, 1250 хүүхдийн сургууль, 560 хүүхдийн цэцэрлэг бүхий хорооллыг барьж байгуулна. | 2020-2024 | 323,600.0 | БНСУ-ын хөнгөлөлттэй зээл | Ашиглалтад орсон сууцны тоо | - | - | - | 3000 | 3000 | 3000 | "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК | Барилга, хот байгуулалтын яам |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| хөгжүүлж иргэдийн орон сууцны хангамж, хүртээмжийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх; | 2 | Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт "Солонго-2" төслийг хэрэгжүүлж, 682 айлын орон сууц, 150 хүүхдийн цэцэрлэг бүхий хорооллыг барьж байгуулна. | 2020-2023 | 59,000.0 | БНСУ-ын хөнгөлөлттэй зээл | Ашиглалтад орсон сууцны тоо | - | - | - | 300 | 200 | 182 | "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК | Барилга, хот байгуулалтын яам |
| | 3 | Нийслэлийн Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Эко-Яармаг 1 төслийг хэрэгжүүлж, 1920 айлын орон сууц, 600 хүүхдийн сургуулийн өргөтгөл, 240 хүүхдийн цэцэрлэг, Үндэсний түүх, соёлын музей, биеийн тамирын талбай бүхий хорооллыг барьж байгуулна. | 2019-2023 | 214,600.0 | Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл | Ашиглалтад орсон сууцны тоо | - | - | 400 | 500 | 500 | 520 | "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК | Барилга, хот байгуулалтын яам |
| | 4 | Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт "Морингийн даваа" төслийг хэрэгжүүлж, 5040 айлын орон сууц, 2500 хүүхдийн сургууль, 1120 хүүхдийн цэцэрлэг бүхий хорооллыг барьж байгуулна. | 2022-2026 | 379,200.0 | Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл | Ашиглалтад орсон сууцны тоо | - | - | - | - | - | 1000 | "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК | Барилга, хот байгуулалтын яам |
| | 5 | Мөрөн хотын нутаг дэвсгэрт "Зүүн Мөрөн" төслийг хэрэгжүүлж, 480 айлын орон сууц, 100 хүүхдийн цэцрлэг бүхий хорооллыг барьж байгуулна. | 2019-2022 | 36,000.0 | Хөгжлийн банкны зээл болон бусад эх үүсвэр | Ашиглалтад орсон сууцны тоо | - | - | 160 | 160 | 160 | - | "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК | Хөвсгөл аймгийн ЗДТГ, Барилга, хот байгуулалтын яам |
| | 6 | Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт "Эко-Яармаг 2" төслийг хэрэгжүүлж, 4752 айлын орон сууц, 2500 хүүхдийн сургууль, 1120 хүүхдийн цэцэрлэг бүхий хорооллыг барьж байгуулна. | 2023-2027 | 417,700.0 | Хөгжлийн банкны болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл | Төслийн хэрэгжилт, хувь | - | - | - | - | - | 10 | "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК | Барилга, хот байгуулалтын яам |
| | 7 | Аймгуудын төвд 3000 айлын орон сууцыг барьж ашиглалтад оруулна. | 2019-2023 | 20,000.0 | Хөгжлийн банкны зээл болон бусад эх үүсвэр | Ашиглалтад орсон сууцны тоо | - | - | 600 | 600 | 1200 | 600 | "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК | Ховд , Архангай, Баянхонгор, Хэнтий, Дорнод аймгуудын Засаг дарга |
| | 8 | Нийслэлийн Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн 5 байршилд шинэ суурьшлын бүсийг хөгжүүлж, 9400 айлын орон сууцыг барьж ашиглалтад оруулна. | 2019-2023 | 1,922,065.4 | Төр хувийн хэвшлийн түншлэл | Ашиглалтад орсон сууцны тоо | - | 1800 | 1800 | 2000 | 2000 | 1800 | "Нийслэлийн орон сууцны корпораци" ХК | Барилга, хот байгуулалтын яам |
| | 9 | Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр Баянголын амны 2000 айлын түрээсийн орон сууцны хороолльг барьж ашиглалтад оруулна. | 2019-2023 | 132,000.0 | БНСУ-ын хөнгөлөлттэй зээл | Ашиглалтад орсон сууцны тоо | - | - | 500 | 500 | 500 | 500 | "Нийслэлийн орон сууцны корпораци" ХК | Барилга, хот байгуулалтын яам |
| | 10 | Сайншанд сумын 2, 6 дугаар баг "Барилгачин хотхон", "Эрчим хотхон" төслийг хэрэгжүүлж, 180 айлын амины орон сууцыг ашиглалтад оруулна. | 2022-2023 | - | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Ашиглалтад орсон сууцны тоо | - | - | - | - | 100 | 80 | Дорноговь аймгийн Засаг дарга | Дорноговь аймгийн ГХБХБГ |
| | 11 | Сайншанд сумын 3 дугаар баг Гэрэлт хотхон, Мааньзав хороолол, Баянбүрд хороолол, Дэлгэр хотхон төслүүдийг хэрэгжүүлж, 684 айлын орон сууцыг ашиглалтад оруулна. | 2021-2023 | - | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Ашиглалтад орсон сууцны тоо | - | - | - | 384 | 180 | 120 | Дорноговь аймгийн Засаг дарга | Дорноговь аймгийн ГХБХБГ |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 12 | Замын-Үүд сумын 1, 4 дүгээр багт Замчин хотхон, Хилчин хороолол, Ургах наран хороолол төслүүдийг хэрэгжүүлж, 700 айлын орон сууцыг ашиглалтад оруулна. | 2022-2023 | - | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Төслийн хэрэгжилт, хувиар | - | - | - | - | 290 | 410 | Дорноговь аймгийн Засаг дарга | Дорноговь аймгийн ГХБХБГ |
| 4.3.2.орон сууцны барилгын эрчим хүчний (цахилгаан болон дулааны) хэрэглээний түвшинг тодорхойлж, гэрчилгээ олгох, дулааны эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээг тарифын бодлогоор дэмжих, тоолууржуулах замаар хэрэглээгээрээ төлдөг тогтолцоонд шилжих; | 1 | Барилгын салбарын эрчим хүчний хэрэглээнээс ялгарч буй хүлэмжийн хийг тооцох үндэсний онцлогт тохирсон хүлэмжийн хийн тооллогын системийг хөгжүүлж, уг системийг ашиглах зааврыг боловсруулна. | 2019-2020 | 408.3 | НҮБХХ-ийн санхүүжилт | Батлагдсан заавар | - | Зөвлөхийг сонгон шалгаруулж, төслийн боловсруулалтыг эхлүүлнэ. | Заавар батлагдсан байна. | - | - | - | Барилга, хот байгуулалтын яам | НАМА төсөл |
| | 2 | Үндэсний онцлогт тохирсон эрчим хүчний хэмнэлттэй загвар төслүүдийг хэрэгжүүлнэ. | 2019-2020 | 632.3 | НҮБХХ-ийн санхүүжилт | Хэрэгжүүлсэн төсөл, тоо | - | 2 | 3 | - | - | - | Барилга, хот байгуулалтын яам | НАМА төсөл |
| | 3 | Ногоон барилгын төлөвлөлтийг боловсронгуй болгох зөвлөмж боловсруулна. | 2019 | 2.8 | НҮБХХ-ийн санхүүжилт | Боловсруулсан зөвлөмж | - | Зөвлөмжийг боловсруулж, олны хүртээл болгосон байна. | - | - | - | - | НАМА төсөл | Барилга, хот байгуулалтын яам |
| | 4 | Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын орон сууцны барилгуудын дулааны хэрэглээг тоолууржуулах арга хэмжээг орон нутгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. | 2019-2023 | 5,000.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Тухайн жилд тоолууржуулах төсөлд хамрагдсан өрхийн тоо | - | Үйл ажиллагааны гүйцэтгэлээр | | | | | Эрчим хүчний яам | Салбарын тусгай зөвшөөрөлтэй байгууллагууд |
| | 5 | Орон сууцны барилгын эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журмыг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, батлуулан хэрэгжүүлнэ. | 2019-2020 | - | - | Батлагдсан журам | - | Төслийг боловсруулна. | Журам батлагдсан байна. | Журмыг хэрэгжүүлнэ. | | | Эрчим хүчний яам | Барилга, хот байгуулалтын яам, Байгаль, орчин аялал жуулчлалын яам, Эрчим хүчний зохицуулах хороо |
| | 6 | Орон сууцны оршин суугчдын усны хэрэглээг бүрэн тоолууржуулж, усыг хэмнэлттэй зарцуулах хэвшлийг бий болгоно. | 2019-2023 | 5000 | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | Тоолууржуулалт, хувь | 86 | 88 | 90 | 93 | 96 | 100 | Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл | Салбарын тусгай зөвшөөрөлтэй байгууллагууд |
| 4.3.3.орон сууцны барилгыг байгалийн нөөцийн хэмнэлттэй төлөвлөх, угсармал хийц, эдлэлээр барьж байгуулахтай холбогдсон норм, дүрэм, стандартыг боловсронгуй болгох, мөрдүүлэх, энэ чиглэлээр инженер, техникийн ажилчдыг сургах, мэргэшүүлэх; | 1 | Барилгыг байгалийн нөөцийн хэмнэлттэй төлөвлөх, барих чиглэлээр салбарын инженер, техникийн ажилтнуудыг чадавхижуулах сургалт зохион байгуулна. | 2019-2023 | - | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | Сургалтад хамрагдсан инженер, техникийн ажилтнуудын тоо | - | Үйл ажиллагааны гүйцэтгэлээр | | | | | Салбарын мэргэжлийн холбоод | Барилга, хот байгуулалтын яам |
| | 2 | Европын Холбооны Улсуудад мөрддөг стандартын шаардлагад нийцүүлэн, "Барилгын дулаан хамгаалалтын норм" БНбД 23-02-09-ийг шинэчлэн боловсруулж, батлуулна. | 2019 | 24.0 | НҮБХХ-ийн санхүүжилт | Шинэчилсэн БНбД | - | БНбД 30-01-04-ийг шинэчлэн боловсруулж, батлуулна. | - | - | - | - | "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ | НАМА төсөл |
| | 3 | Барилга байгууламж инженерийн шугам сүлжээний засвар ашиглалтын хугацааны жишиг норм /БНбД 13-04-03/-ийг шинэчлэн боловсруулж, батлуулна. | 2019 | 10.0 | Барилга, байгууламжийн норм, нормативын сан | Шинэчилсэн БНбД | - | БНбД 30-01-04-ийг шинэчлэн боловсруулж, батлуулна. | - | - | - | - | "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ | НАМА төсөл |
| | 4 | Үндэсний онцлогт нийцсэн, эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын шаардлагыг тодорхойлсон стандартыг боловсруулж, батлуулна. | 2019-2020 | 30.0 | Барилга, байгууламжийн норм, нормативын сан | Батлагдсан стандарт | - | Зөвлөхийг сонгон шалгаруулж, төслийн боловсруулалтыг эхлүүлнэ. | Стандартыг батлуулна. | - | - | - | "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ | Стандарт, хэмжилзүйн газар |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3.4.ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн дэд бүтцийг бий болгох, инженерийн хангамжид эрчим хүч, ус хангамжийн хэмнэлттэй, дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж, хэрэгслийг нэвтрүүлэх ажлыг бүх талаар дэмжих; | 1 | Эрчим хүчний хэмнэлттэй барилга барьсан, барилгын материал үйлдвэрлэсэн, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох журмыг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж батлуулна. | 2019 | - | - | Журам | - | Зөвлөхийг сонгон шалгаруулж, төслийн боловсруулалтыг эхлүүлнэ. | Журам батлагдсан байна. | Журмыг хэрэгжүүлнэ. | | | Барилга, хот байгуулалтын яам, | Байгаль, орчин аялал жуулчлалын яам, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо |
| | 2 | Газрын хэт гүний дулааныг (1500м доош) ашиглах ТЭЗҮ-ийг боловсруулж, загвар төсөл хэрэгжүүлнэ. | 2019-2023 | 3,000.0 | Улсын төсөв | Төслийн хэрэгжилт, хувь | - | Зөвлөхийг сонгон шалгаруулж, төслийн боловсруулалтыг эхлүүлнэ. | ТЭЗҮ-ийг боловсруулсан байна. | Загвар төслийг хэрэгжүүлнэ. | | | Барилга, хот байгуулалтын яам | Хувийн хэвшил |
| | 3 | Инженерийн хангамжийн шугам сүлжээг хонгилын системээр төлөвлөх стандартыг боловсруулж, батлуулна. | 2019 | 10.0 | Барилга, байгууламжийн норм, нормативын сан | Батлагдсан стандарт | - | Стандартыг батлуулсан байна. | - | - | - | - | "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ | Стандарт, хэмжилзүйн газар |
| | 4 | Шуудуугүй технологийн аргаар инженерийн шугам сүлжээг сэргээн засварлах төсөл хэрэгжүүлж, нийслэлд ус, хангамж, ариутгах татуургын 48 км шугам сүлжээг доторлох ажлыг хийж гүйцэтгэнэ. | 2019-2021 | 20,825.0 | Гадаад орнуудын хөнгөлөлттэй зээл | Төслийн хүрээнд доторлосон цэвэр, бохир усны шугам сүлжээ, у/м | - | Үйл ажиллагааны гүйцэтгэлээр | | | | | Нийслэлийн Засаг дарга | Ус сувгийн удирдах газар |
| 4.3.5.орон нутгийн засаг захиргаа, сууц өмчлөгчдийн оролцоотойгоор дулааны алдагдал ихтэй, угсармал орон сууцны барилгуудыг дулаалах, ашиглалтын шаардлага хангахгүй болсон орон сууцны барилгуудыг буулган, шинээр барих төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх; | 1 | Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгуудыг буулган, дахин барилгажуулах төслийг үе шаттай хэрэгжүүлж, Улаанбаатар хотод 3746 айлын, Дархан-Уул аймагт 176 айлын орон сууцыг ашиглалтад оруулна. | 2019-2023 | - | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Шинээр ашиглалтад орсон орон сууц /3746/ | 301 | 746 | 1000 | 1176 | 500 | 500 | Нийслэлийн Засаг дарга | Барилга, хот байгуулалтын яам |
| | 2 | Нийтийн зориулалттай угсармал орон сууцны барилгуудад газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийлгэж, гэрчилгээжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2019-2023 | 1,000.0 | Орон нутгийн төсөв | Үнэлгээ хийлгэж, гэрчилгээжүүлсэн орон сууцны барилга, тоогоор | - | 80 | 80 | 80 | 80 | 80 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар |
| 4.3.6.эрчим хүчний хэмнэлттэй, ногоон орон сууцны нийлүүлэлтийг дэмжих санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох; | 1 | Угсармал орон сууцны барилгын дулаан-техникийн шинэчлэлтийн санхүүжилтийн механизмыг боловсруулж, 375 блок барилгын дулаалгын төслийг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2019-2023 | 90,000.0 | Улс, орон нутгийн төсөв, гадаад орны хөнгөлөлттэй зээл | Төсөлд хамрагдсан орон сууцны тоо, блок | 1 | 24 | 51 | 100 | 100 | 100 | Нийслэлийн Засаг дарга | Монголын барилгачдын нэгдсэн холбоо |
| | 2 | Орон сууцны барилгын дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлтийг дэмжсэн зээл, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлнэ. | 2019-2021 | 498.9 | НҮБХХ-ийн санхүүжилт | Зээлийн бүтээгдэхүүн | - | Холбогдох судалгааг хийсэн байна. | Зээлийн бүтээгдэхүүнийг гаргасан байна. | - | - | - | НАМА төсөл | Монголын банкны холбоо |
| 4.3.7.ахуйн хог, хаягдлын менежментийн шинэ тогтолцоог бий болгох; | 1 | Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт өдөрт 300 тн хог хаягдал хүлээн авч, ангилж ялгах хүчин чадалтай хог ангилах автоматжуулсан үйлдвэр барина. | 2019-2020 | 10,000.0 | Орон нутгийн төсөв | Үйлдвэр | - | Зөвлөхийг сонгон шалгаруулж, төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж, төслийг эхлүүлнэ. | Үйлдвэр ашиглалтад орсон байна. | - | - | - | Нийслэлийн Засаг дарга | Хувийн хэвшил |
| | 2 | Хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч үйлдвэрлэх 32 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулна. | 2019-2023 | - | Концессийн гэрээ | Дулааны цахилгаан станц | - | Зөвлөхийг сонгон шалгаруулж, төслийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах ажлыг эхлүүлнэ. | Тэзү, зураг төслийг боловсруулсан байна. | | Барилга угсралтын ажлыг эхлүүлнэ. | | Үндэсний хөгжлийн газар | Нийслэлийн Засаг дарга |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3.8.орон сууцны хотхон, хорооллын төлөвлөлтөд ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай, хүртээмжтэй ил, далд автозогсоол, оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх тохилог орчинг бүрдүүлэх шаардлагыг тусган хэрэгжүүлэх; | 1 | Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартын төслийг боловсруулж, батлуулна. | 2019-2020 | 20.0 | Барилга, байгууламжийн норм, нормативын сан | Стандарт | | Төслийг боловсруулна. | Стандартыг батлуулна. | Стандартыг мөрдөж, хэрэгжүүлнэ. | | | Барилга, хот байгуулалтын яам | Стандарт, хэмжилзүйн газар |
| | 2 | Орон сууцны хотхон хорооллын ногоон байгууламжийн усалгаанд хөрсний болон хур тунадасны усыг хуримтлуулан ашиглах усан сан бүхий эко орчинг бүрдүүлнэ. | 2021-2023 | | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Төслийн тоо | - | Үйл ажиллагааны гүйцэтгэлээр | | | | | Нийслэлийн Засаг дарга | Салбарын тусгай зөвшөөрөлтэй байгууллагууд |
| | 3 | Орон сууцны хотхон, хорооллын төлөвлөлтөд оршин суугчдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг болзошгүй үер усны аюулаас хамгаалах усны барилга байгууламж, үерийн хамгаалалтын далан суваг, хөрсний болон автозамын борооны ус зайлуулах системийг цогцоор төлөвлөнө. | 2019-2023 | 139,000.00 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Шинээр ашиглалтад орсон үерийн байгууламж, далан суваг, км | - | Үерийн эрсдэлийн үнэлгээ хийлгэж, үерийн далан сувгийн зураглал боловсруулна. | Төслийг үе шаттай хэрэгжүүлнэ. | | | | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Нийслэлийн Захирагчийн ажлын алба, Аймгуудын ГХБХБГ |
| | 4 | Орон сууцны хотхон хорооллын ногоон байгууламжийн хэмжээ, тавигдах шаардлагыг зохицуулах стандартыг боловсруулж батлуулна. | 2019-2020 | - | - | Батлагдсан стандарт | - | Холбогдох судалгааг хийсэн байна. | Стандартыг батлуулна. | Стандартыг мөрдөж, хэрэгжүүлнэ. | | | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | Стандарт, хэмжилзүйн газар |
| | 5 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцсэн орон сууцны болон олон нийтийн барилга байгууламжийн орчны болон дотоод зохион байгуулалтын заавал дагаж мөрдөх үндэсний стандартыг боловсруулж, батлуулна. | 2019-2020 | 20.00 | Барилга, байгууламжийн норм, нормативын сан | Батлагдсан стандарт | | | Төслийг боловсруулна. | Стандарт батлагдсан байна. | Стандартыг мөрдөж, хэрэгжүүлнэ. | | "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ | Стандарт, хэмжилзүйн газар |
| | 6 | Хот, суурин газруудад шинээр баригдах орон сууцны хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээг хонгилын системээр төлөвлөх, барих төслийг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2019-2020 | - | Орон нутгийн төсөв | Ашиглалтад орсон хонгил, у/м | - | Үйл ажиллагааны үйцэтгэлээр | | | | | Дархан-Уул аймгийн Засаг дарга, Нийслэлийн Засаг дарга | Салбарын тусгай зөвшөөрөлтэй байгууллагууд |
| | 7 | Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн норм ба дүрэм БНбД 30.01.04-ийг шинэчлэн боловсруулж батлуулна. | 2019-2020 | - | - | Батлагдсан БНбД | - | Төслийг боловсруулна. | БНбД батлагдсан байна. | - | - | - | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | Барилга, хот байгуулалтын ам |
| | **Дүн** | | | **3,779,646.7** | | | | | | | | | | |
| **Зорилт 4.Төрийн халамж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамж, нөхцлийг сайжруулахад онцгойлон анхаарах чиглэлээр** | | | | | | | | | | | | | | |
| 4.4.1.орон сууцны зориулалттай гадаад, дотоодын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн 30-аас доошгүй хувийг зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамж, нөхцлийг сайжруулахад зориулах; | 1 | Орон сууцны хангамж, нөхцлийг сайжруулах шаардлагатай зорилтот өрх, иргэнийг тодорхойлох зорилгоор өрхийн мэдээллийн нэгдсэн сангаас өрхүүдийн амьжиргааны түвшин, амьдарч байгаа орон сууцны төрлийн бодит судалгаа, мэдээллээр бодлого боловсруулагчдыг хангах нөхцлийг бүрдүүлнэ. | 2019-2023 | - | - | Үнэн зөв, бодит мэдээлэл | - | Мэдээллийн сангийн баяжилтыг сайжруулж, бодлого боловсруулагчдыг судалгаа, мэдээллээр хангаж ажиллана. | | | | | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар |
| | 2 | Өрхийн амьжиргааг дэмжих, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бусад хөтөлбөр, төслийг ядуурлын түвшингээс доогуур орлоготой иргэдийг орон сууцаар хангах, тэдний орон сууцны нөхцөлийг сайжруулах арга хэмжээтэй уялдуулан зохицуулна. | 2019-2023 | - | Улс, орон нутгийн төсөв | Орон сууцтай болсон зорилтот бүлгийн иргэдийн тоо | - | Үйл ажиллагааны гүйцэтгэлээр | | | | | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Сангийн яам |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3 | Зорилтот бүлгийн иргэдэд зориулж орон сууц барих хөрөнгө оруулагчид гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагаас хөрөнгө оруулалтын зээл авахад нь зээлийн баталгаа гаргуулах ажлыг зохион байгуулна. | 2019-2023 | - | - | Хөрөнгө оруулалтын зээлийн баталгаа гаргуулсан ААН-ийн тоо | - | Үйл ажиллагааны гүйцэтгэлээр | | | | | Монголын барилгачдын нэгдсэн холбоо | Хөгжлийн банк "Монгол даатгал" ХХК |
| 4.4.2.ядуурлын түвшингээс доогуур амьжиргаатай 0-18 насны 4-ээс дээш хүүхэдтэй гэр бүл, өрх толгойлсон эцэг /эх/, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудыг тэргүүн ээлжинд халамжийн болон түрээсийн орон сууцаар хангах бодлогыг хэрэгжүүлэх; | 1 | Бага, дунд орлоготой иргэдэд зориулсан орон сууцны барилгын бүтээн байгуулалтад эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт техник, технологи бүхий үндэсний үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүний хэрэглээг дэмжинэ. | 2019-2023 | - | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Дотоод нийт бүтээгдэхүүнд барилгын салбарын эзлэх хувь, үнээр | - | Үйл ажиллагааны гүйцэтгэлээр | | | | | Төрийн захиргааны төв байгууллагууд | "Эрэл" групп, салбарын тусгай зөвшөөрөлтэй байгууллагууд |
| | 2 | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон орон сууцнуудыг түрээслэх замаар зорилтот бүлгийн иргэд өөрийн өмчлөлийн орон сууцтай болох нөхцлийг бүрдүүлж, 5000 иргэнийг орон сууцжуулна. | 2019-2023 | - | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Батлагдсан журам | - | Журам батлагдсан байна. | Журмыг хэрэгжүүлж, 5000 иргэнийг орон сууцтай болгоно. | | | | "Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ | Барилга, хот байгуулалтын яам |
| | 3 | Залуу гэр бүлийг орон сууцжуулах, орон сууцны түрээсээ урьдчилгаанд шилжүүлэн тооцуулах журмыг боловсруулж, хэрэгжүүлнэ. | 2019-2023 | - | Улсын төсөв | Холбогдох шийдвэр | - | Холбогдох судалгааг хийсэн байна. | Журмын төслийг боловсруулж батлуулна. | Журмын хэрэгжилтийг хангаж ажиллана. | | | Барилга, хот байгуулалтын яам | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам |
| | 4 | "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээг хийлгэх ажлыг зохион байгуулж, тайлан бүрийг Засгийн газарт танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулж ажиллана. | Хуулийн хугацаанд | - | - | Холбогдох шийдвэр | - | Хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр тайлагнаж ажиллана. | | | | | Барилга, хот байгуулалтын яам | - |
| 4.4.3.төрийн албан хаагч орон сууц худалдан авах, орон сууцны нөхцөлөө сайжруулахад нь төрөөс дэмжлэг үзүүлэх хүрээнд дараах арга хэмжээнүүдийг судалж, боломжит хувилбараар хэрэгжүүлэх: | 1 | Ядуурлын түвшингээс доогуур орлоготой 0-18 насны 4-ээс дээш хүүхэдтэй гэр бүл, өрх толгойлсон эцэг /эх/, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудын орон сууцны урьдчилгаа болон түрээсийн төлбөрт хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2019-2023 | 114,000.0 | Улс, орон нутгийн төсөв | Зарцуулсан хөрөнгө, сая төгрөг | - | - | 28,500.0 | 28,500.0 | 28,500.0 | 28,500.0 | Сангийн яам | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| | 2 | Орон сууц захиалан бариулах, зах зээлд борлуулагдаж байгаа орон сууцнуудаас худалдан авах санхүүжилтийг шийдвэрлүүлж, аймаг бүрт 120-оос доошгүй айлын түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг орон сууцжуулах ажлыг зохион байгуулна. | 2019-2023 | - | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Түрээсийн орон сууцанд хамрагдсан өрхийн тоо | 1512 | 570 | 240 | 240 | 240 | :20 | Баян-Өлгий, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл аймгуудын Засаг дарга | Барилга, хот байгуулалтын яам |
| | 3 | Албан тушаалын орон сууцыг холбогдох эрх зүйн хүрээнд хувьчлах, үүнээс төвлөрөх хөрөнгөөр дараагийн орон сууцыг барьж алба хаагчдыг орон сууцжуулах арга хэмжээг авна. | 2019-2023 | - | - | Орон сууцтай болсон албан хаагчдын тоо | - | Үйл ажиллагааны гүйцэтгэлээр | | | | | Батлан хамгаалах яам | Хувийн хэвшил |
| | 4 | Зориулалтыг нь өөрчлөн албан тушаалын орон сууцаар ашиглаж байгаа барилгыг холбогдох эрх зүйн хүрээнд дахин төлөвлөж, орон сууц барих төслийг хэрэгжүүлнэ. | 2019-2023 | - | - | Ашиглалтад орсон орон сууцны тоо | - | Үйл ажиллагааны гүйцэтгэлээр | | | | | Батлан хамгаалах яам | Хувийн хэвшил |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 5 | Төрийн албан хаагчдын орон сууцны хангамж, нөхцлийн судалгааг нарийвчлан гаргаж, төрийн албан хаагчдын орон сууцны хангамж, нөхцлийг сайжруулах талаар журам боловсруулж хэрэгжүүлнэ. | 2019-2023 | - | - | Батлагдсан журам | 127,585 | Холбогдох судалгааг хийсэн байна. | Журмыг боловсруулж батлуулна. | Журмыг хэрэгжүүлнэ. | | | Засгийн газрын хэрэг эрхлэх газар | Сангийн яам |
| | 6 | Төрийн албан хаагчдын цалинг эдийн засгийн өсөлт, инфляцийн түвшин, амьжиргааны өртөгтэй уялдуулан орон сууцны урт хугацаатай зээл авахад хүрэлцэхүйц хэмжээгээр үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 2019-2023 | - | Улсын төсөв | Цалингийн өсөлтийн хувь | - | Үйл ажиллагааны гүйцэтгэлээр | | | | | Сангийн яам | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| | 7 | Аймгийн төвөөс алслагдсан сумдад ажиллаж, амьдарч байгаа эрүүл мэнд, боловсрол, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын албан хаагчдын ажиллаж, амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх хүрээнд албаны орон сууцаар бүрэн хангана. | 2019-2023 | - | - | Шинээр бүрдүүлсэн албан орон сууц, айлын тоогоор | - | Үйл ажиллагааны гүйцэтгэлээр | | | | | Аймгуудын Засаг дарга нар | Холбогдох төрийн захиргааны төв байгууллагууд |
| 4.4.4.малчдын орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, тэдний нүүдэлчин ахуй нөхцөлд тохирсон, байгаль орчинд ээлтэй, ус, дулаан, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцтай болоход нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд авч хэрэгжүүлэх; | 1 | Малчдын өвөлжөөн дэх орон сууцны нөхцөлийг сайжруулах, зуны улиралд хэрэглэх зөөврийн сууц авахад зориулж төлбөрийн уян хатан нөхцөлтэй, урт хугацаатай, бага хүүтэй зээл олгох ажлыг зохион байгуулна. | 2019-2023 | - | Төр хувийн хэвшлийн түншлэл | Зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамрагдсан малчин өрхийн тоо | - | Үйл ажиллагааны гүйцэтгэлээр | | | | | Бүх шатны Засаг дарга нар | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам |
| | **Дүн** | | | **114,000.0** | | | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | **12,137,556.4** | | | | | | | | | | |